

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ:

Ч.ГҮНЖДАГВА

ЭКО ЖОРЛОН БАРИУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Баримтын төрөл: Ажлын даалгавар

Баримтын нэр: Эко жорлон байгуулах

Зорилго:

Өмнөговь аймгийн БОАЖГ-аас 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах саналд сөрөг нөлөөллийг бууруулах хөрсөн бүрхэвчийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулж уурхай болон тосгоны бус дэх нүхэн жорлонгуудыг эко жорлон болгох, Цогтцэций сумын гэр хорооллын ахмад настан, зорилтот бүлгийн айл өрхийн хөрсний бохирдлыг бууруулж, орчин үеийн шийдлээр эко жорлон байгуулах.

Эко жорлон барих газрын байршил:

Байршил – 1: Өмнөговь аймаг Цогтцэций сумын төвд 1 бүхээгтэй – 8 ширхэг.

Байршил – 2: Уурхайн засварын гадна 2 бүхээгтэй – 1 ширхэг.

Байршил – 3: Компанийн аж ахуйн хашаанд 2 бүхээгтэй – 1 ширхэг.

Тоо хэмжээ:

Нийт 10 ширхэг

- 2 бүхээгтэй – 2 ширхэг
- 1 бүхээгтэй – 8 ширхэг

Техникийн шаардлага:

No	Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага	
1	Ерөнхий шаардлага	✓ Монгол улсад мөрдөж буй MNS 5924:2015 стандарт норм, болон бусад норм дүрмүүдийг баримтлан ажиллах;
2	Суурин нүх	✓ Суурийн нүхний эзэлхүүнийг хэрэглэгчийн тооноос хамааруулан тооцох; ✓ Суурийн нүхний өндрийг газрын хөрсний хөлдөлтийн түвшинтэй уялдуулж, хөрсний уснаас дээш 2 м-ээс багагүй түвшинд ухах;
3	Хөрсний хамгаалалт	✓ Хөрснөөс тусгаарлах материал нь төмөр, бетон, пластик байх; ✓ Бүхээгний ар талын хананаас хойшхи нүхний дунд хэсэгт бохирыг соруулах, ухаж цэвэрлэхэд зориулсан хүзүүвч бүхий зориулалтын тагтай байх ✓ Бетон, пластик кольцоог нүхэнд байрлуулахдаа өргөгч механизмаар өргөж байрлуулах ба хөдөлгөөнгүй байхаар ивээс хийж өгсөн байх; ✓ Бетон болон пластик кольцо нь 5 тонн багтаамжтай ба хөрсний бохирдлоос бүрэн хамгаалагдсан байх;

4	Шал	<ul style="list-style-type: none"> ✓ Шал нь кольцааны хүндийн жинг даах хэмжээний бат бөх байх ба бетон болон пластик материалыаар хийгдсэн байх; Хаалга түгжих цүүтэй, нугастай, цоожтой байх;
5	Бүхээг	<ul style="list-style-type: none"> ✓ Бүхээгийн хана, дээвэр, тэдгээрийн уулзвар зайд завсаргүй хаалга нь бүрэн онгойж хаагдаж байхаар, цэвэр, өнгө үзэмжтэй байна. Материал: /Мод, төмөр/; ✓ Бүхээгийн хаалга гадна дотор талдаа түгжээтэй байх бөгөөд шөнийн цагт гэрэлтүүлэгтэй, бүхээгний хаалганы дээр ялаа, шавьж орохос хамгаалсан тор бүхий цонхтой байх; ✓ Бүхээг дотор ариун цэврийн цаас, өлгүүр, тагтай хогийн сав, цэвэрлэгээний тоноглол, хэрэгсэл байрлуулсан байх;
6	Хаяавч	<ul style="list-style-type: none"> ✓ Жорлонд цас, борооны ус орох, ялааны авгалдай хөрсөөр нэвтэрч гарахаас хамгаалан жорлонгийн бүхээгний эргэн тойронд 500 мм-ийн зайнд бетон зуурмаг, чулуу, тоосго, хайрга зэрэг материалыаар жорлонгийн суурийг нүхний амсартай зайд завсаргүй холбосон 100 мм-ийн зузаан, жорлонгийн хананаас гадагш налуу бүхий хаяавч хийх;
7	Агааржуулалтын хоолой	<ul style="list-style-type: none"> ✓ Жорлон бүр агааржуулалтын хоолойтой байх ба уг хоолой нь бүхээгийн ар талын ханын дунд хэсэгт нүхний харалдаа байрлуулсан байх; ✓ Салхивчийн хоолойн өндөр бүхээгний арын хананын өндөрөөс 200 мм-ээс багагүй өндөр, голч нь 200 мм буюу дөрвөлжин бол 200мм x 200мм хэмжээтэй хийж, түүний дээд үзүүрт малгайвч, ялааны тороор тоноглосон байх;

Бүхээгний хэмжээ

Бүхээгийн ялгаа	Нүүрэн талын өндөр /мм/	Ар талын өндөр /мм/	Хажуу талын өргөн /мм/
Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд зориулсан 1 бүхээгтэй	2400	2100	1800

Жич: Жорлонгийн бүхээгийн хаалгыг нарны гэрлийн тусгалын эсрэг тал руу харуулж байрлуулах бөгөөд хаалганы дээд талд 400мм урт, 200 мм өргөн цонхтой байна.

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

1	Баримт бичиг	<ul style="list-style-type: none"> ✓ Компанийн дэлгэрэнгүй танилцуулга; ✓ Ажил гүйцэтгэлийн туршлага, биелэлтийг нотлох баримт; ✓ Санхүүгийн болон техникийн санал;
---	--------------	--

Зураг 1 Загвар зураг

